



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-7
1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай /үргэлжлэв/	4-7

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 30-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 70 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 04 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Ц.Баатархүү, Б.Бат-Эрдэнэ, Э.Болормаа, Б.Заяабал, Б.Мөнхсоёл;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, С.Зулпхар, М.Нарантуяа-Нара, Г.Уянгахишиг, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Б.Батцэцэг, Б.Баярбаатар, Х.Булгантуяа, Л.Гантөмөр, Л.Мөнхбаатар, Г.Очирбат, Б.Тулга;

Тасалсан: Н.Алтаншагай, Ч.Анар, Н.Батсүмбэрэл, Х.Баттулга, А.Ганбаатар, Г.Ганбаатар, Х.Ганхуяг, Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан, Д.Жаргалсайхан, Ц.Мөнхбат, П.Мөнхтулга, З.Мэндсайхан, П.Наранбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Б.Түвшин, А.Ундраа, Д.Цогтбаатар, Б.Чойжилсүрэн, Ж.Энхбаяр, Р.Эрдэнэбүрэн;

Хоцорсон: Б.Батбаатар -03 минут, Д.Батлут -05 минут, Х.Болормаа -02 минут, Ж.Галбадрах -06 минут, С.Ганбаатар -09 минут, Д.Ганбат -09 минут, Б.Жаргалан -06 минут, Ц.Мөнхтуяа -05 минут, Ч.Номин -06 минут, Н.Номтойбаяр -02 минут, О.Саранчулуун -12 минут, Л.Соронзонболд -04 минут, Да.Цогтбаатар -03 минут.

Нийтийн өргөдлийг холбогдох Байнгын хороонд хуваарилсныг танилцуулах

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж Монгол Улсын иргэн Ц.Батболд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсгийн “Хэрэв гишүүн бүрэн эрх дуусгавар болсноос хойш ажил эрхлээгүй бол 12 сарын хугацаанд гишүүний үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж, бага цалинтай ажилд орсон бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж, ... олгоно.” гэсэн заалтыг хүчингүй болгох хуулийн төсөл санаачлах нийтийн өргөдөл ирүүлсэн нь Монгол Улсын 18 насанд хүрсэн 100,467 /нэг зуун мянга дөрвөн зуун жаран долоо/ иргэний санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Төрийн байгуулалтын болон Өргөдлийн байнгын хороодод хуваарилсныг танилцуулав./10:07/

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай /үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссан тухай мэдэгдэв./10:08/

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай асуудлын хэлэлцүүлэг Улсын Их Хурлын гишүүний үгээр үргэлжлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж Улсын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 2025.10.31-ний өдрийн Баасан гарагийн хуралдаанаар явуулахаар хойшлуулав./10:17/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 14 минут үргэлжилж, 126 гишүүнээс 85 гишүүн хүрэлцэн ирж, 67.5 хувийн ирцтэйгээр 10 цаг 18 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 04 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Пүрэвдорж: Эрхэм Монголын ард түмэн болон Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Гишүүдийн ирц 126-аас 70 болж, 55,6 хувьтай боллоо. Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар нэг асуудлыг хэлэлцэнэ. 1 дүгээрт бол Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95.3-д нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж заасан байгаа. Нийтийн өргөдлийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Монгол Улсын иргэн Цогбадрахын Батболд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсгийн хэрэв гишүүн бүрэн эрх дуусгавар болсноос хойш ажил эрхлээгүй бол 12 сарын хугацаанд гишүүний үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж, бага цалинтай ажилд орсон бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж олгоно гэсэн заалтыг хүчингүй болгуулах асуудлаар хуулийн төслийг санаачлах нийтийн өргөдөл ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл, гомдлын системд 2025 оны 9 сарын 24-ний өдөр нийтэлсэн.

Уг өргөдөл 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 100467 иргэний санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороонд хуваарилсан. Төрийн байгуулалтын байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороо энэ иргэдийн гаргасан өргөдөлд дурдсан асуудлыг хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэх нь зүйтэй. Тэгээд яаралтай энэ асуудлыг оруулж ирэхийг хүсье.

10.07 цаг

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай /үргэлжлэв/

Хэлэлцэх асуудал 1 байгаа. Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах санал, саналын асуудлаар үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Өнгөрсөн 5 дахь өдрийн хуралдаанаар энэ асуудлыг хэлэлцсэн. Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд гаргах хүсэлтийг хэлэлцэж, гишүүд асуулт асууж, үг хэлсэн байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг ажлын 3 өдрийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан. Тэгээд Ардчилсан намын бүлгийн дарга үг хэлэхгүй юм байна. Тэгэхээр завсарлага дууслаа. Яг энэний үг, миний үг хэлэхийн урдуур та орж үг хэлээд, завсарлага авсан байгаа. Тэгэхээр би энэ асуудлаар тодорхой үг хэлэх ёстой. Өөрөөр хэлбэл эндээс үг хэлбэл гишүүдийн саналд нөлөөлөх магадлалтай учраас би өөрийнхөө суудал дээрээс гишүүнийхээ байр сууриас үг хэлнэ.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар Их Хурлын гишүүн албан үүргээ гүйцэтгэж байх үед гэмт хэргийг түдгэлзүүлэх агуулга бүхий ийм саналыг оруулж ирсэн. Би та нарт нэг зүйлийг хэлж танилцуулъя гэж бодож байна. 30, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4.4-д хэргийг түдгэлзүүлэх тухай асуудал байгаа. Хэрвээ 1.3 дээр тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаарх гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэсэн, шийдвэрлэж байгаа бол гэж байгаа юм.

Мөн түүнчлэн хэргийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх гээд 34.17.4 дээр шүүх хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх маргаан улсын Үндсэн хуулийн цэцэд үүссэн тохиолдолд хэрэг шийдвэрлэх, хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ гэж ийм 2 том заалттай. Ер нь бол Их Хурлын гишүүн хэрвээ цагдаа, хууль хяналтын байгууллагад эрүүгийн хэрэг үүсээд, прокуророор хянагдаад ч юм уу, аль эсвэл шүүхээр хэлэлцэж байх явцад энэ маргаан үүсгэгдэх юм бол бүгд зогсоно гэсэн үг. Өөрөөр хэлбэл Их Хурлын гишүүнийг түдгэлзээд юу, ажлаасаа гишүүнээсээ буух хүртэл тэр хэрэг бүгдээрээ зогсоно гэсэн үг. Дахиад 4, 5 жил, 4, 5 удаа дахиад Их Хурлын гишүүнээр сонгогдоод явбал энэ хэрэг бүүр ингээд бүүр хэдэн жилээр хойшлогдох ийм магадлалтай байгаа. Аль ч шатад.

Тийм учраас энэ бол маш юу байдаг юм, тэгээд л хэрэг хийчхээд энд Их Хурлын гишүүний бүрэн эрхийн цаана нуугдах ийм нөхцөл байдлыг энэ бичгийн хүрээнд бий болж байгаа. Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэххээд, хэдэн жилээр хойшлуулж байгаа тохиолдлууд байгаа шүү дээ. Сайнзориг гишүүн энэ тэр бүгдээрээ энийг мэдэж байгаа. Тэгээд маргаан үүсгэххээд байлгачихдаг. Хэрвээ маргаан үүсгэххээд ингээд л хаячихвал өөрөөр хэлбэл энэ Ганбаатар гишүүний гаргасан тэр хүсэлтийг хүлээж авах ч үгүй, шийдэх ч үгүй, хүлээж авч, маргаан үүсгэххээд шийдэх ч үгүй, аль эсвэл ингээд гацаагаад хэдэн жилээр хойш нь татчихвал энэ Их Хурлын гишүүн гэмт хэрэг хийчхээд л тэгээд энд гишүүнийхээ бүрэн эрхийн цаана нуугдаад байгаад байх ийм боломжийг бий болгож байгаа юм. Тийм учраас энэ асуудлыг би өөрийнхөө Бүлэг дээр нэлээн тодорхой хэлж, тайлбарлаж, гишүүддээ өгсөн байгаа. Тэгээд энэ бол ард иргэдийн дургүйцлийг асар их хүргэх ийм зүйл шүү. Энэ бол парламентын нэр хүндийг бас маш тийм унагаах ийм асуудал болж байгаа шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо Байнгын хорооны саналаар, 1 минутаа авахгүй. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Энэ гишүүдийг ирцэд оруулъя, ирц. Яг ирсэн гишүүдийн тал нь Ардчилсан намынхан байна шүү. Энэ хооронд гишүүдийн ирц бүрдэж байх хооронд энэ Улсын Их Хурлаар бас хэлэлцэх асуудал багадаад байна. Өнөөдөр ганцхан

асуудалтай, ингээд санал хураагаад дуусах гэж байна. 9 цаг одоо хэд болж байгаа юм бэ дээ, 9 цаг 30 минут гээд дуусах нь, 10 цаг 30 минут гээд дуусах нь.

Тэгэхээр энэ хооронд Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүд өөрсдийнхөө өргөн барьсан, санаачилсан хуулиудаа энэ Их Хурлаар хэлэлцүүлэх асуудлыг, ялангуяа Ардчилсан намынхан хувь хүний эрх, эрх чөлөө, чөлөөт зах зээл, энэ талаар баримталдаг тэр бодлогын баримт бичгүүд, хуулиудаа оруулж ирж, хэлэлцвэл илүү хурдан шийдэгдэх ийм боломжтой байна шүү. Тэгээд манай Ардын намынхан ч гэсэн бас Засгийн газартаа хэлэх хэрэгтэй байна, яаралтай хуулиудыг оруулж ир.

Ялангуяа өчигдөр Бейсен дарга надтай уулзаад, тэр Казахстаны тэтгэврийн, тэтгэвэртэй холбоотой олон улсын гэрээг соёрхон батлах тэр асуудлыг ярьсан. Энэ асуудлаар бол манай Аюушийн Ариунзаяа гишүүн байнга гишүүдийн групп дотор шахаж, шаардаж бичдэг. Дээрээс нь олон нийт ч гэсэн энэ сошиалаараа энэ асуудлыг ярьж, хэвлэл мэдээлэлд ярилцлага өгдөг. Аубакир гишүүн бас энэ асуудлыг хурдан оруулж ирээд, асуудлаа ирэх долоо хоногийн дотор оруулаад, хэлэлцүүлээд, батлуулбал энэ тэтгэврийн асуудал тодорхой хэмжээгээр 2 тал, тэнд ажиллаж байсан иргэд тэндээсээ тэтгэвэр авах ийм боломж нь Казахстанд ажиллаж байсан хүмүүс Казахстанасаа тэтгэвэр авах ийм боломжийг нээж өгч байгаа юм. Энэ манай дотоодоос бас их гарахгүй. Ихэнх зардал нь бол цаад талаасаа гарах ийм үр ашигтай хэлэлцээр байгаа. Энэ асуудлыг тухайн үед 2 намын хоорондын зөрчилдөөнөөс болоод унасан тохиолдол бий. Тийм учраас энэ алдаагаа маш хурдан засаад, 1 сарын 1-нээс энэ хэлэлцээр батлагдаж, хэрэгжих ёстой. Энэ асуудлыг Ариунзаяа гишүүнээ та, Ариунзаяа гишүүнээ та Аубакир сайдтай яаралтай яриад, ирэх долоо хоногийн хурлаар оруулж ирээрэй.

Өнөөдөр Газрын тосны тухай хууль болон гишүүдийн өргөн барьсан, Бадамсүрэн гишүүний өргөн барьсан Газрын тосны тухай хууль болон Оюун-Эрдэнэ нарын гишүүдээс өргөн барьсан Түр хороо байгуулах тухай асуудал Байнгын хороогоороо хэлэлцэж, шийдвэрлэгдээгүй учраас чуулган руу орж ирээгүй байгаа. Тийм учраас Сэдэйдорж дарга, тэгээд байхгүй юу. Ардын намын гишүүд орж ирэхгүй байна. С.Ганбаатар гишүүнээ энэ санал хураалтыг хойшлуулчих уу? Санал хураалтыг маргааш баасан гаргийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Ер нь бол Байнгын хорооны санал хураалт ийм байсан шүү. Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2 дахь заалт, Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заасныг зөрчсөн эсэх талаарх Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалгах байсан. Саналыг хойшлуулсан. Байнгын хорооны, санал хураалтын дүнтэй хамаараад 2 дугаарт нь Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2 дахь заалт, Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг эгүүлэн татна гэж заасныг зөрчсөн эсэх талаарх Улсын Их Хурлаас Үндсэн

хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн санал хураалтаар санал хураах байсан. Тэгээд саналыг хойшлуулж байна.

10.17 цаг

Газрын тосны тухай хууль болон, би дөнгөж сая хэллээ шүү дээ. Газрын тосны тухай хууль болон Түр хороо байгуулах 2 асуудал Байнгын хороогоороо өчигдөр хэлэлцэгдээгүй учраас чуулганаар орж ирэх боломжгүй болсон байгаа.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА